



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/444

Мандалговь

А.И.Вампиловын нэрэмжит Олон улсын
XII их наадамд оролцоход
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8, 16.1.10, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 2.1.6, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 15 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин, Төрийн соёрхолт, Зууны манлай уртын дуучин Н.Норовбанзадын нэрэмжит Төв Халхын дуулалт жүжгийн театрын уран бүтээлчид Оросын холбооны улсын Эрхүү хотноо зохион байгуулагдах А.И.Вампиловын нэрэмжит Олон улсын XII их наадамд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Дэмжлэг үзүүлэх зардлыг 2153300 (Хоёр сая нэг зуун тавин гурван мянга гурван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

Гурав. А.И.Вампиловын нэрэмжит Олон улсын XII их наадамд амжилттай оролцохыг Төв Халхын дуулалт жүжгийн театр (Д.Доржсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191245

Аймгийн Засаг даргын 2019 он
12 дугаар сарын 18-ны өдрийн 144 дугаар
захирамжийн хавсралт



А.И.ВАМПИЛОВЫН НЭРЭМЖИТ ОЛОН УЛСЫН ХИИ ИХ НААДАМД
ОРОЛЦОХОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТӨСВИЙН ТООЦОО

№	Зардлын утга	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Вагоны билет	22 хүн ирэх, буцах	18225 х2	801900
2	Онгоцны тийз	2 хүн ирэх, буцах	337850 х 2	1351400
	ДҮН			2153300